



Зөгийчдийн дунд цахим санал асуулга хэрэгжүүлж байна

BeeDep төслөөс Монголын зөгийн аж ахуйн бодит нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг тогтоохын тулд цахим санал асуулгыг ээлж дараалан хэрэгжүүлдэг билээ. Энэ удаад тус төслийн Facebook хуудсаар дамжуулж 4-10 дугаар санал асуулгыг доорх агуулгын хүрээнд хэрэгжүүлж байна.

Дугаар 4 : Зун, намрын маллагааны менежмент

Дугаар 5 : Эх зөгий бойжуулах

Дугаар 6 : Балт, тоост ургамлын ашиглалт

Дугаар 7 : Зөгийн балны стандарт

Дугаар 8 : Өвөлжилтийн бэлтгэл

Дугаар 9 : Өвөлжих байрны нөхцөл


Дугаар 10 : Хаврын маллагааны менежмент

Оролцогчдоос ирүүлсэн мэдээллийг нэгтгэн дүгнээд Facebook хуудсаар дамжуулан мэдээлэх болно. Зөгийн аж ахуй эрхлэгч нар тус санал асуулгад цахим хэлбэрээ хялбархан оролцох боломжтой тул бидэнтэй хамтран ажиллахыг уриалж байна.

Мөн өмнөх 3 дугаар цахим санал асуулга нь бүл салгах агуулгаар хэрэгжсэн ба үүнд нийт 46 зөгийчин оролцож хамтран ажиллав. Тус санал асуулгын дүн, үүнтэй холбогдсон төслийн зөвлөмжийг видео бичлэг хэлбэрээр Facebook хуудсанд нийтэлсэн.

Асуулт 3-1. Та бүл салгахдаа доорх тохиолдлуудын алийг нь ашигладаг вэ? (Хэдэн ч хариулт сонгож болно).

46 хариулт



3 дугаар санал асуулгын дүнгээс: Санал асуулгад хамрагдагсдын 23.9 % нь бал хураалт эхлэхээс өмнө бүх бүлгийг эсвэл ихэнх бүлээ хувааж салгадаг гэж хариулсан байна. Гэсэн хэдий ч бүл салгах үедээ өндөг үрвэлдэй, мөн ажилчин зөгийн олон цөөнийг харгалзан цаашид 3-н долоо хоногийн хугацаанд зөгийн хүч авах болон балт ургамлын цэцэглэлтийн хугацааг урьдчилан тооцож үндсэн бүлийн хүчийг сааруулахгүй байхад анхаарах шаардлагатай юм. Тухайлбал салгах гэж буй үндсэн бүл нь 10 орчим жаазтай (давхарлаж болохуйц) буюу хүч сайтай болсон байх нь чухал байдаг.


Цахим сургалт зохион байгуулав

Нэгдүгээр сарын 19-ны өдөр Булган аймаг дахь ХАА-н МСҮТ-ийн "Зөгийчин, зөгийн аж ахуй эрхлэгч" ангийн суралцагсадад "зөгийн аж ахуйн үндсэн ойлголт" сэдвээр цахим сургалт хийв. BeeDep төсөл нь тус сургалт үйлдвэрлэлийн төвтэй зөгийн аж ахуйн технологи хөгжүүлэх, мөн сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах зэргээр хамтран ажиллаж байна.

Туршлага солилцох цахим уулзалт зохион байгуулав

Нэгдүгээр сарын 27, 28, 29-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Орхон сумын зөгийчдийн дунд туршлага солилцох уулзалтыг цахимаар амжилттай зохион байгуулав. Тус уулзалтанд Орхон сумын нийт 26 зөгийчин гурван хэсэгт хуваагдан оролцсон ба зөгийн уурагт тэжээл, эх зөгий бойжуулах арга, өвөлжих байрны хүрэлцээ зэрэг сэдвийн хүрээнд харилцан туршлага солилцсон нь үр дүнтэй арга хэмжээ боллоо. Цаашид туршлага солилцох цахим уулзалтыг бусад орон нутгийн зөгийчдийн дунд хийхээр төлөвлөж байна.

Төслийн хүрээнд Монголын зөгийн аж ахуйн хөгжлийг дэмжихэд чиглэсэн нэгдсэн гарын авлага боловсруулан бэлтгэхээр ажиллаж байгаа билээ. Нэгдсэн гарын авлага нь санал асуулгын үр дүн, зөгийн аж ахуй эрхлэгчдийн санал, туршлага, орон нутгуудад хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн зэрэг мэдээллүүдийг нэгтгэх байдлаар эцэслэн боловсрогдох болно.



Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

